

УБХТ-ийн Удирдах Зөвлөлийн 2022 оны 07 дүгээр сарын 07-ний өдрийн хурлын 07/01/33 тоот шийдвэрийн 1 дүгээр хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ ҮНДЭСНИЙ БА ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТРЫН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Улаанбаатар хотын Худалдааны Танхим /цаашид “УБХТ” гэх/-ын дэргэдэх Үндэсний ба Олон Улсын Арилжааны Арбитр (англи нэр нь: National and international Commercial Arbitration) (цаашид “Арбитр” гэх) нь зохион байгуулалтын хувьд УБХТ-аас хараат бус, бие даасан үйл ажиллагаа явуулах, байнгын ажиллагаатай арбитрын байгууллага мөн.
- 1.2. Арбитр нь арбитрын ажиллагааг зохион байгуулах, арбитрын бүрэлдэхүүнд зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй байна.
- 1.3. Арбитр нь бие дааж арбитрын ажиллагаа явуулж маргаан шийдвэрлэх эрхгүй. Арбитрын ажиллагаа явуулж маргаан шийдвэрлэх эрх гагцхүү арбитрын бүрэлдэхүүнд хадгалагдах бөгөөд энэ үүргээ хараат бусаар хэрэгжүүлнэ.
- 1.4. Арбитр нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгох бөгөөд дүрмээр нарийвчлан зохицуулаагүй харилцааг дүрмийн үндсэн зарчим, агуулгад нийцүүлэн зохицуулна.
- 1.5. Арбитр нь өөрийн эмблемтэй байх бөгөөд албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ.
- 1.6. Арбитр Улаанбаатар хотод оршин байрлана.

Хоёрдугаар бүлэг

Арбитрын зорилго, бүрэн эрх

- 2.1. Арбитрын зорилго нь иргэд, байгууллага хоорондын эдийн засаг, бизнесийн харилцаатай холбоотой иргэний эрх зүйн маргааныг арбитрын хэлэлцээр болон хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 2.2. Арбитр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 2.2.1. арбитрын ажиллагааг хууль, дүрмийн дагуу зохион байгуулах;
 - 2.2.2. арбитрын хэлэлцээр, харьяалал бүхий маргааныг хянан шийдвэрлэх;
 - 2.2.3. арбитрчийг бэлтгэх, сургах, бүртгэх, олон нийтэд нээлттэй зарлах ажлыг зохион байгуулах;
 - 2.2.4. арбитрын үйл ажиллагааны чиглэлээр судалгааны ажил хийх, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, байр сууриа илэрхийлэх;
 - 2.2.5. арбитрын тухай хууль тогтоомж, арбитр, зуучлалын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр мэдээлэл хийх, сургалт, семинар зохион байгуулах, бусад байгууллага, иргэнтэй хамтран ажиллах;
 - 2.2.6. түр арбитрт арбитрын ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх;
 - 2.2.7. олон улсын арбитрын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 2.2.8. арбитрын ажиллагааны нууцыг хадгалах;
 - 2.2.9. хуулиар хориглоогүй, УБХТ болон арбитрын үйл ажиллагаанд харшлахгүй

- бусад үйл ажиллагаа явуулах.
- 2.3. Арбитр нь УБХТ-ын Удирдах зөвлөлд жил бүр ажлаа тайлагнана.

Гуравдугаар бүлэг

Арбитрын удирдлага, зохион байгуулалт

- 3.1. Арбитрын удирдах дээд байгууллага нь УБХТ-ын Удирдах зөвлөл (цаашид “Удирдах зөвлөл” гэх) байна.
- 3.2. Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 3.2.1. арбитрыг үүсгэн байгуулах, татан буулгах;
- 3.2.2. арбитрын дүрмийг батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 3.2.3. арбитрын дарга, зөвлөх гишүүдийг томилох, чөлөөлөх, цалин, хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;
- 3.2.4. арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журмыг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 3.2.5. арбитрчдын нэрсийн жагсаалтыг батлах, жагсаалтаас хасах;
- 3.2.6. арбитрын үндсэн ба нэмэлт зардлын хэмжээ, арбитрчийн ажлын хөлс, урамшууллын хэмжээг батлах;
- 3.2.7. арбитрчдын ёс зүйн дүрмийг батлах;
- 3.2.8. арбитрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 3.2.9. УБХТ-ын дүрэмд заасан бусад.
- 3.3. Арбитр нь дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, зөвлөх гишүүд, арбитрч, нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ.
- 3.4. УБХТ-ын Гүйцэтгэх захирал нь Арбитрын дарга байна.
- 3.5. Арбитрын даргын бүрэн эрхийн хугацаа УБХТ-ын Гүйцэтгэх захирлаар томилогдсон хугацаагаар, зөвлөх гишүүдийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд улируулан томилж болно.
- 3.6. Арбитр нь 5-7 зөвлөх гишүүнтэй байж болох бөгөөд эдгээр нь орон тооны бус байна.
- 3.7. Арбитрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 3.7.1. арбитрын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, арбитрын үйл ажиллагааг сурталчлах, төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3.7.2. Удирдах зөвлөлийн хуралд эрхлэх хүрээнийхээ асуудлыг хэлэлцүүлэх;
- 3.7.3. бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал, шийдвэр гаргах;
- 3.7.4. арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх;
- 3.7.5. арбитрын ажилтнуудын орон тоо, цалингийн сангийн хэмжээг тогтоох
- 3.7.6. арбитрыг гадаад, дотоодод төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах;
- 3.7.7. Арбитрын тухай Монгол Улсын хуульд заасан маргааныг эцэслэн шийдвэрлэх;
- 3.7.8. Хэргийн талууд арбитрчийг томилж чадаагүй тохиолдолд Арбитрын дарга нэхэмжлэгч, хариуцагчийн хүсэлтийг үндэслэн арбитрчийг сонгон томилно.
- 3.7.9. арбитрт гаргах өргөдөл, гэрээний болон мэдэгдэх хуудасны загварыг батлах;
- 3.7.10. арбитрт гаргасан аливаа хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч эцэслэн шийдвэрлэх;
- 3.7.11. арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга болон арбитрчдын гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх;
- 3.7.12. шаардлагатай бусад дүрэм, журмыг батлах.
- 3.8. Арбитрын даргын түр эзгүйд түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга орлоно.
- 3.9. Арбитрын өдөр тутмын үйл ажиллагааг ажлын алба хариуцан хэрэгжүүлэх бөгөөд арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.



- 3.10. Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргыг арбитрын дарга томилно.
- 3.11. Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 3.11.1. арбитрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах;
 - 3.11.2. арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн байдлыг хангаж хуралдааны нарийн бичгийн дарга болон зөвлөх гишүүдийг удирдлагаар хангах;
 - 3.11.3. арбитрын ажилтнуудыг сонгон шалгаруулж даргад танилцуулах;
 - 3.11.4. арбитрын даргын эзгүйд түр орлох;
 - 3.11.5. арбитрыг төлөөлөн гадаад, дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцах;
 - 3.11.6. арбитрын даргад ажлаа тайлагнах;
 - 3.11.7. арбитрч болон захиргааны ажилтнуудаас үйл ажиллагааны тайлан авах, үнэлгээ өгөх;
 - 3.11.8. арбитрчийн эрхийг сунгах, чөлөөлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр Удирдах зөвлөлд санал гаргах;
 - 3.11.9. арбитрын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны талаарх саналаа арбитрын даргад хүргүүлэх;
 - 3.11.10. арбитрын үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх, бэхжүүлэх, сурталчлах чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
 - 3.11.11. арбитрын ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах;
 - 3.11.12. арбитрын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн эзэмшил, ашиглалтыг удирдан зохион байгуулах;
 - 3.11.13. арбитрын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах.
- 3.12. Арбитрын ажлын алба нь Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, хуралдааны нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ.
- 3.13. Арбитрын хуралдааны нарийн бичгийн дарга нь эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.13.1. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргаас хуваарилсан арбитрын хэргийг хүлээн авч арбитрын ажиллагааг эхлүүлэх ажиллагааг шуурхай явуулах;
 - 3.13.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллах;
 - 3.13.3. Хэргийг илтгэх, хуралдааны бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх;
 - 3.13.4. Арбитрын бүрэлдэхүүн болон талуудыг хэргийн талаарх мэдээллээр хангах;
 - 3.13.5. Арбитрын ажиллагааны бэлтгэл хангах, зохион байгуулалт хийх;
 - 3.13.6. Ерөнхий нарийн бичгийн дарга буюу ажлын албаны даргад арбитрын процесс ажиллагааны талаар шуурхай мэдээлж, дэмжлэг тусламж авах;
 - 3.13.7. Арбитрын бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;
 - 3.13.8. Арбитрын ажиллагааны нууцыг чандлан хадгалах;
 - 3.13.9. Бусад.
- 3.14. Арбитр, түүний Дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, зөвлөх гишүүд, ажлын алба буюу нарийн бичгийн дарга нар нь арбитрын бүрэлдэхүүний маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглоно.

Дөрөвдүгээр бүлэг

Арбитрчид тавигдах шалгуур, арбитрчийн жасгаалтад бүртгэх

- 4.1. Арбитрын дарга арбитрчийн эрхтэй, дараах шаардлага хангасан арбитрчийг сонгон шалгаруулж, Удирдах зөвлөлд танилцуулж арбитрчийн нэрсийн жагсаалтад бүртгэнэ:

- 4.1.1. 30-аас дээш насны, дээд боловсролтой, ял шийтгүүлж байгаагүй;
 - 4.1.2. мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай;
 - 4.1.3. арбитрч бэлтгэх сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан;
 - 4.1.4. одоогийн ажиллаж байгаа ажил, албан тушаал нь арбитрчаар ажиллахад харшлахгүй;
 - 4.1.5. хэргийг хянан шийдвэрлэхэд цаг зарцуулах боломжтой, шударга, хэргийг хараат бус, бие даасан байдлаар шийдвэрлэх ёс зүйтэй;
 - 4.1.6. арбитрын ажиллагаа болон хуралдааныг хууль, дүрмээр тогтоосон цаг хугацаанд удирдан явуулах, шийдвэрээ үндэслэлтэй гаргах, арбитрын шийдвэрийг ойлгомжтой, алдаагүй бичиж гаргах чадвартай байх;
 - 4.1.7. хуульд заасан бусад.
- 4.2. Арбитрчийн нэрсийн жагсаалтад арбитрчийн нэр, төрсөн он, сар, өдөр, мэргэжил, мэргэшил, эрдмийн цол хэргэм зэрэг, эрхэлж буй ажил, оршин суугаа хаяг зэрэг шаардлагатай мэдээллүүдийг оруулсан байна.
 - 4.3. Арбитрч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ бие даасан, хараат бус, шударга байх зарчмыг баримтлах, мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй бөгөөд арбитрчийн ёс зүйн дүрмийг чандлан сахина.
 - 4.4. Арбитрч нь маргаанд оролцогч талуудад өмнө нь мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж байгаагүй, тэдгээртэй төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн хувьд холбоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
 - 4.5. Арбитрчийн нэрсийн жагсаалтад орох хүсэлт гаргасан иргэдийн хүсэлт, мөн арбитрчийг нэрсийн жагсаалтаас хасах, түдгэлзүүлэх, улируулан сонгох асуудлыг арбитрчдын зөвлөлөөр хэлэлцүүлэн танхимын удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.
 - 4.6. Арбитрчийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь арбитрын ажиллагаа явагдаж буй хэрэг хянан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж буй арбитрчийн бүрэн эрх, ажиллах нөхцөлд тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусах хүртэл ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
 - 4.7. Арбитрчийг томилсон, арбитрчийн жагсаалтаас хассан, түдгэлзүүлсэн тухай Удирдах зөвлөлийн шийдвэр нь эцсийн бөгөөд энэ талаар гомдол гаргах эрхгүй.
 - 4.8. Арбитрчийн эрх, үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:
 - 4.8.1. арбитрын бүрэлдэхүүнээс гарах хүсэлт гаргасан;
 - 4.8.2. арбитрч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон;
 - 4.8.3. арбитрчдын нэрсийн жагсаалтаас хасагдсан;
 - 4.8.4. хууль тогтоомжид заасан бусад.
 - 4.9. Арбитрчийг дараахь тохиолдолд нэрсийн жагсаалтаас хасна:
 - 4.9.1. арбитрын зорилго, үйл ажиллагаа, нэр хүндэд харш үйлдэл, эс үйлдэл хийсэн;
 - 4.9.2. арбитрчаар ажиллах явцдаа гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон;
 - 4.9.3. арбитрчаар ажиллахад хориглох ажил албан тушаалд томилогдсон.

Тавдугаар бүлэг

Арбитрын эд хөрөнгө, санхүүжилт

- 5.1. Арбитрын эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө, тэдгээртэй адилтгах бусад активаас бүрдэнэ.
- 5.2. Арбитр нь ашиг олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж өөрийгөө санхүүжүүлж болно.
- 5.3. Арбитрын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 5.3.1. арбитрын зардал;
 - 5.3.2. сургалт, семинар зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болон хэвлэн нийтлэх зэрэг дүрэмд заасан үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 5.3.3. зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх замаар олсон хөрөнгө;

- 5.3.4. лавлагаа, тодорхойлолт гаргах болон бусад холбогдох үйл ажиллагаанаас олсон орлого.
- 5.4. Арбитр нь орлогоо зөвхөн дүрэмд заасан үйл ажиллагаанд захиран зарцуулна.

Зургаадугаар бүлэг

Арбитраас төрийн болон бусад байгууллагатай харилцах

- 6.1. Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллагын зүгээс арбитрын үйл ажиллагаанд, арбитрын зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй байх зарчим баримтална.
- 6.2. Арбитр маргаан хянан шийдвэрлэхээс бусад, өөрийн эрхлэх хүрээний асуудлаар төр, захиргааны байгууллагатай зөвшилцөх, хэлэлцээ хийх, шаардлага тавих зэргээр хамтран ажиллаж болно.
- 6.3. Арбитр нь бусад төрийн бус байгууллага, худалдаа, үйлдвэрлэлийн нийгэмлэг, холбоод, танхим, арбитрай харилцахдаа харилцан хүндэтгэх, дэмжин туслах, хамтран ажиллах зарчим баримтална.

Долоодугаар бүлэг Бусад

- 7.1. Арбитрын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.
- 7.2. Арбитр нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, сурталчлах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллага, арбитр, холбоодтой хамтран ажиллах гэрээ, хэлцэл, санамж бичиг байгуулах болон гишүүнээр элсэж болно.
- 7.3. Энэхүү дүрэм нь Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

_____оОо_____